БАТЛАВ
СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.БИЛГҮҮНБААТАР

2026 оны 02 дугаар сарын ..... өдөр

# ЖАРГАЛАНТ СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026.02.24 Жаргалант сум

ЗОРИЛГО: Жаргалант сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх шалтгаан нөхцөл, хүчин зүйлсийг тогтоон арилгах зэрэг чиглэлээр зохих хууль хяналтын болон бусад байгууллагуудын оролцоо, гүйцэтгэх үүрэг, зохион байгуулалтын арга хэмжээг тодорхойлж, хамтын ажиллагааг уялдуулж гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад оршино.

| Д/Д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Төсөв | Суурь түвшин | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хариуцан хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэх |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДЛЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| 1.1 | Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, зөвлөлөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, тайлангаа хагас, бүтэн жилээр гарган тайлагнах | Хагас, бүтэн жилээр | ГХУС | 2025 онд 2 удаа хуралдсан | Зохион байгуулсан хурлын тоо, гарсан шийдвэр, тайлангийн биелэлт | Салбар зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжиж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил сайжирна, хамтын ажиллагаа бэхжин | Ажлын алба | Зөвлөлийн гишүүд |
| 1.2 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, зохих үр дүн гаргасан | Жилдээ | ГХУС | 2025 онд 4 иргэн, 4 ААН-ийг шагнасан | Шагнагдсан байгууллага, албан хаагч, иргэдийн тоо; гаргасан үр дүн | Урьдчилан сэргийлэх ажилд иргэд, байгууллагын оролцоо нэмэгдэж, | Ажлын алба | Зөвлөлийн гишүүд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллага, албан хаагч, иргэнийг шагнаж, урамшуулах ажлыг зохион байгуулах | | | | | идэвх санаачилга дээшилнэ | | |
| 1.3 | Сумын төрийн захир-гааны болон төрийн үйлчилгээний байгуул-лага төрийн өмчийн байгууллагуудын дунд ГХУСАЗСЗ-н ажлыг сурталчилсан байдал. Ард иргэдэд чиглэсэн манлайллын ажлыг зохион байгуулсан байдал Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон шалгаруулж урамшуулах | IV улиралд | ГХУС | - | Сурталчилгаанд хамрагдсан байгууллагын тоо; зохион байгуулсан арга хэмжээний тоо; | Байгууллагуудын хууль дэг журам сахих байдал сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурна, хамт олны эерэг соёл төлөвшинө | Зөвлөлийн гишүүд | Байгууллагууд |
| 1.4 | Сумын ГХУСАЗСЗ-н гишүүдээс хариуцсан байгууллагын ажилтан албан хаагчдыг нэгдсэн арга хэмжээнд хэрхэн идэвх санаачилгатай ирц бүрдүүлэлтийг хангаж үйл ажиллагаанд оролцсон идэвхээр нь үнэлж шагнаж урамшуулах | IV улиралд | ГХУС | - | Арга хэмжээнд оролцсон байгууллага, албан хаагчдын тоо; ирцийн хувь (%); идэвхээр | Нэгдсэн арга хэмжээнд оролцоо нэмэгдэж, байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, урьдчилан сэргийлэх ажил үр дүнтэй хэрэгжинэ | Ажлын алба | Зөвлөлийн гишүүд |
| 1.5 | Бусад аймаг сумуудтай туршлага судлах, ГХУСАЗСЗ-н гишүүдийг идэвхижүүлэх | Жилдээ | ГХУС | Булган аймгийн Хангал сум, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн | Зохион байгуулсан туршлага судлах арга хэмжээний тоо; хамрагдсан гишүүдийн тоо; нэвтрүүлсэн | Гишүүдийн мэдлэг, ур чадвар, идэвх нэмэгдэж, урьдчилан сэргийлэх ажилд шинэ арга барил нэвтэрч үр дүн сайжирна | Ажлын алба | Зөвлөлийн гишүүд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сумуудтай туршлага судалсан | сайн туршлагын тоо | | | |
| й1.6 | Салбар зөвлөлийн гишүүд өөрсдийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг гарган хагас бүтэн жилээр тайланг ирүүлэх | Хагас, бүтэн жилээр | | - | Төлөвлөгөө ирүүлсэн байгууллагын тоо; хагас, бүтэн жилийн тайлангийн биелэлт; тайлангийн чанар | Байгууллагуудын урьдчилан сэргийлэх ажил төлөвлөгөөтэй, уялдаа холбоотой хэрэгжиж, тайлагнал сайжирна | Зөвлөлийн гишүүд | Ажлын алба |
| 1.7 | Багуудын ИНХ-н зөвлөл ГХУСэргийлэх жилийн төлөвлөгөөг гарган ажиллах "Гэмт хэрэг зөрчилгүй баг" аяныг зохион байгуулах | Жилээр | ГХУС | - | Төлөвлөгөө гаргасан багийн тоо; аяныг зохион байгуулсан арга хэмжээний тоо; | Иргэдийн хууль сахих ухамсар нэмэгдэж, багийн түвшинд гэмт хэрэг, зөрчил буурч, аюулгүй орчин бүрдэнэ | Ажлын алба | 3 багийн ИНХ, ажлын алба |
| 1.8 | Иргэдэд зориулсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" нээлттэй өдөрлөгийг жилд 1 удаа зохион байгуулах | Жилээр | ГХУС | - | Өдөрлөгт хамрагдсан иргэдийн тоо; оролцсон байгууллагын тоо; тараасан гарын авлага, мэдээллийн материалын тоо | Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоо нэмэгдэнэ | Ажлын алба, Нийгмийн ажилтан | Зөвлөлийн гишүүд, Байгууллагууд |
| **ХОЁР.ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| 2.1 | **ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 2.1.1 | Байгалиа хамгаалъя" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ой хээрийн түймэр, хулгайн мод бэлтгэл, хулгайн ан ав, байгалийн түгээмэл | I, IV улиралд | ГХУС | 2025 онд эргүүл шалгалтыг 10 удаа зохион байгуулж | Зохион байгуулсан эргүүл, шалгалтын тоо; хамрагд-сан алба хаагчдын | Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил буурч, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, | Зөвлөлийн гишүүд | БОХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тархацтай нөөцийг хууль бусаар ашиглах зэрэг ажил дээр хөрш зэргэлдээ сумуудтай хамтарсан эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулж | | | 6 зөрчил илрүүлсэн | тоо; илрүүлсэн зөрчлийн тоо | байгалийн нөөцийг хамгаалах ажил сайжирна | | |
| 2.1.2 | Сумын хэмжээнд эргүүл шалгалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах | Жилээр | ГХУС | 2025 онд нийт 209 удаагийн эргүүл шалгалтыг хийж ажилласан | Зохион байгуулсан эргүүлийн тоо; хамрагдсан алба хаагчдын тоо; илрүүлсэн зөрчлийн тоо; урьдчилан сэргийлсэн тохиолдлын тоо | Нийтийн хэв журам, аюулгүй байдал сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурч, иргэдийн аюулгүй орчин бүрдэнэ | Цагдаагийн хэсэг | Ажлын алба |
| 2.1.3 | Дүрс бичлэгийн техник хэрэгслийн чанарыг сайжруулах, камержуулалтыг нэмэгдүүлэх | Жилдээ | | 2025 онд суурьшлын бүсэд 66 камераас 21 камер ажиллаж байсан. | Шинээр суурилуулсан камерын тоо; шинэчилсэн техник хэрэгслийн тоо; камержуулсан байршлын тоо | Хяналт, аюулгүй байдал сайжирч, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ | Сумын Засаг дарга | Цагдаагийн хэсэг |
| 2.1.4 | Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, гудамж талбай, бүтээн байгуулалтын аюулгүй байдлыг хангуулах, байнгын эргүүлийн сайн дурын ажилтан томилон ажиллуулах | Жилээр | ГХУС | 2025 онд нийт 320 өрхөд санамж анхааруулгыг өгч ажилласан. | Байнгын эргүүлийн сайн дурын ажилтны тоо; зохион байгуулсан эргүүл, хяналтын тоо; илрүүлсэн зөрчлийн тоо | Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, гудамж талбай, бүтээн байгуулалтын аюулгүй байдал сайжирч, гэмт хэрэг, осол, зөрчил буурч, иргэдийн оролцоо нэмэгдэнэ | Ажлын алба | 3 багийн ажлын алба |
| 2.1.5 | Соёлын үл хөдлөх түүх дурсгал, дурсгалт газруудын бүрэн бүтэн | Жилдээ | ГХУС | 2025 онд 2 удаа эргүүл | Зохион байгуулсан эргүүл | Соёлын үл хөдлөх өв, дурсгалт газар хамгаалагдаж, гэмт | СМТ | Ажлын алба |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байдалд хяналт тавих, эргүүл шалгалтыг ажлыг зохион байгуулах бүртгэлжүүлэх, пайзжуулах | | | шалгалтын ажлыг хийсэн. | шалгалтын тоо; бүртгэлжүүлсэн дурсгалт газар, пайзжуулсан байдал; илрүүлсэн зөрчлийн тоо | хэрэг, эвдрэл буурч, иргэдийн мэдлэг, хариуцлага нэмэгдэнэ | | |
| 2.1.6 | Ойн хээрийн болон ахуйн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулах, иргэдэд сургалт мэдээлэл хүргэж ажиллах | I, IV улиралд | ГХУС | 2025 онд ой хээрийн 3, объектын 3 гал түймэр гарч эргүүл шалгалтыг нийт 3 удаа хийсэн. | Эргүүл шалгалтын тоо, зөвлөмж хүргүүлсэн иргэн, ААН-н тоо | Ойн хээрийн болон ахуйн гал түймрийн тоо буурна | Орхон аймгийн ОБГ | Ажлын алба |
| **2.2** | **ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 2.2.1 | “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2026” аяныг зохион байгуулах | Жилдээ | ГХУС | 2025 онд нийт 16459 тээврийн хэрэгсэл, зөрчилтэй 2626 иргэнийг шалгасан. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо; шалгасан тээврийн хэрэгслийн тоо; зөрчилтэй иргэний тоо | Иргэдийн хөдөлгөөний соёл дээшилж, замын осол, зөрчил буурч, замын хөдөлгөөний аюулгүй байдал сайжирна | Орхон аймгийн Цагдаагийн газар | Ажлын алба |
| 2.2.2 | Орхон аймгийн цэцэрлэгүүдийн дунд жил бүр зохион байгуулагддаг “Замын хөдөлгөөний – Цагаан толгой 2026” уралдаанд оролцох | II улиралд | ГХУС | - | Бэлтгэлд хамрагдсан баг, хүүхдийн тоо; амжилттай оролцсон байдал | Цэцэрлэгийн хүүхэд багачуудын замын хөдөлгөөний мэдлэг дээшилж, замын соёл төлөвшинө, уралдаан оролцоог идэвхжүүлнэ | 3 дугаар цэцэрлэг | Цагдаагийн хэсэг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.3 | “Сургуулийн цагдаа“ хөтөлбөрийн хэрэгжил-тэд хяналт тавих, хэрэглэгдэхүүнээр хангах | II улиралд | ГХУС | - | Хяналт шалгалтын тоо; хангалттай хэрэглэгдэхүүн ээр хангагдсан сургууль, хүүхдийн тоо; тайлангийн биелэлт | “Сургуулийн цагдаа” хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж, хүүхдүүдийн аюулгүй байдал, замын хөдөлгөөний мэдлэг дээшилнэ | Ажлын алба | ЕБС |
| **2.3** | **ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | |
| 2.3.1 | Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөрш зэргэлдээ сумуудтай хамтарсан эргүүл шалгалтыг зохион байгуулах | Жилдээ | ГХУС | - | Зохион байгуулсан хамтарсан эргүүл, шалгалтын тоо; хамрагдсан алба хаагчдын тоо; илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо | Хулгайлах гэмт хэрэг буурч, хөрш сумын хамтын ажиллагаа сайжирч, иргэдийн аюулгүй орчин дээшилнэ | Цагдааг ийн хэсэг | Хангал, Баруун бүрэн сумын цагдааг ийн хэсэг |
| 2.3.2 | Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар малчдад зориулсан уулзалт, зөвлөгөө өгөх | Жилдээ | ГХУС | - | Зохион байгуулсан уулзалтын тоо; оролцсон малчдын тоо; тараасан зөвлөмж, гарын авлагын тоо | Малчдын мэдлэг, ухамсар нэмэгдэж, мал хулгайлах гэмт хэрэг буурч, мал хамгаалалт сайжирна | Нийгмийн ажилтан, ажлын алба | Цагдааг ийн хэсэг, салбар зөвлөл ийн гишүүд |
| **ГУРАВ. СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| 3.1 | ЕБС-н 6-12 ангиудын дунд ёс зүйн зөрчилгүй манлайлагч анги хамт олныг шалгаруулах уралдаан зарлах | Жилдээ | ГХУС | - | Уралдаанд оролцсон ангийн тоо; шалгарсан ангийн тоо; гаргасан үр дүнгийн тайлан | Сурагчдын ёс зүй, хамтын ажиллагаа дээшилж, сургууль дахь сахилга бат сайжирч, манлайлагч ангиудыг тодруулан урамшуулах | ЕБС | Ажлын алба |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2 | ЕБС-н 1-5 ангиудын дунд мэндлэх хүндлэх ёс суртахуунтай анги хамт олныг шалгаруулах | Жилдээ | ГХУС | - | Уралдаанд оролцсон ангийн тоо; шалгарсан ангийн тоо; гаргасан үр дүнгийн тайлан | Сурагчдын ёс суртахуун, харилцааны соёл дээшилж, эерэг хамт олны орчин бүрдэж, ангийн хамтын ажиллагаа сайжирна | ЕБС | Ажлын алба |
| 3.3 | “Нууц хадгалах” захидлын хайрцаг аялуулах | Жилдээ | ГХУС | - | Захидлын хайрцагт ирсэн захидлын тоо; оролцсон анги, байгууллагын тоо; аялуулах маршрут биелсэн байдал | Хүүхэд, сурагчид, иргэдийн нууц хадгалах мэдлэг, хандлага дээшилж, мэдээллийн аюулгүй байдал сайжирна | ЕБС | Ажлын алба |
| 3.4 | “Өвлүүлэх сургамж” аяныг зохион байгуулах | Жилдээ | ГХУС | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо; оролцсон сурагч, иргэдийн тоо; | Сурагчдын мэдлэг, ойлголт дээшилж, урьдчилан сэргийлэх арга барилд суралцаж, гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх үр дүн нэмэгдэнэ | Ахмадын хороо, ЕБС | Ажлын алба |
| 3.5 | ЕБС-н сурагчдын “Ирээдүйн манлайлал” клуб ажиллуулах | Жилдээ | ГХУС | - | Үйл ажиллагаанд оролцсон сурагчдын тоо; зохион байгуулсан арга хэмжээний тоо; клубын үйл ажиллагааны тайлан | Сурагчдын манлайлал, багийн ажиллагаа, ёс зүй дээшилж, ирээдүйн манлайлагчдын ур чадвар хөгжиж, идэвх санаачилга нэмэгдэнэ | ЕБС | Ажлын алба |
| 3.6 | 3-р цэцэрлэгтэй хамтран бага насны хүүхдийн хүмүүжил, ёс | Жилдээ | ГХУС | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо; | Бага насны хүүхдийн ёс суртахуун, | 3 дугаар цэцэрлэг | Ажлын алба |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | суртахууныг дээшлүүлэх зорилгоор үлгэрч аав, ээж үйл ажиллагааг зохион байгуулах, өв соёл, ёс заншлаар дамжуулан үлгэрлэх | | | | оролцсон хүүхэд, эцэг эхийн тоо; үлгэрлэсэн өв соёл, ёс заншлын тоо | хүмүүжил дээшилж, эцэг эхийн оролцоо нэмэгдэж, өв соёл, ёс заншил хадгалагдана | | |
| 3.7 | Сумын ГХУСАЗСЗ-тэй хамтран эцэг эхчүүд, хүүхдүүдийн дунд "ЭРҮҮЛ АГААР–ЭМ" арга хэмжээг зохион байгуулах | II улиралд | ГХУС | Жил бүр уламжлал болон явагддаг | Зохион байгуулсан арга хэмжээний тоо; оролцсон хүүхэд, эцэг эхийн тоо; | Хүүхдүүд, эцэг эхчүүдийн эрүүл мэнд, агаарын бохирдлын талаарх мэдлэг дээшилж, эрүүл амьдралын хэв маяг төлөв-шинө, урьдчилан сэргийлэх мэдлэг нэмэгдэнэ | 3 дугаар цэцэрлэг | Ажлын алба |
| 3.8 | Нийгмийн зорилтод бүлгүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх | Жилдээ | ГХУС | - | Зөвлөгөө авсан иргэдийн тоо; зохион байгуулсан уулзалт, сургалтын тоо; хамрагдсан зорилтот бүлгийн тоо | Иргэдийн сэтгэл зүйн дархлаа, амьдрах ухаан сайжирч, эрсдэлт зан үйл, гэр бүлийн хүчирхийлэл, зөрчил буурах нөхцөл бүрдэнэ | Ажлын алба | Орхон аймгийн сэтгэл зүйчдийн холбоо |
| 3.9 | Үндсэн хууль болон бусад хуулийг таниулж, сурталчлах ажлыг зохион байгуулах | I дүгээр улиралд | ГХУС | 2025 онд Бөхийн барилдаан зохион байгуулсан. | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо; хамрагдсан иргэдийн тоо | Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, Үндсэн хууль болон бусад хуулийн хэрэгжилт, сахилга бат сайжирна | Ажлын алба | Байгууллагууд |
| **ДӨРӨВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЛААР** | | | | | | | | |
| 4.1 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажлаар хяналт шалгалт хийх | Тухай бүрд | ГХУС | 2025 онд нийт 7 удаагийн | Зохион байгуулсан хяналт | Хяналт шалгалтын хүрээ өргөжиж, бусад чиглэлийн | Ажлын алба | Зөвлөлийн гишүүд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хяналт шалгалтыг хийсэн. | шалгалтын тоо; хамрагдсан байгууллага, объектын тоо; илрүүлсэн зөрчил, дутагдлын тоо | зөрчил, дутагдал илрүүлж засагдаж, нийтийн эрх ашиг, аюулгүй байдал сайжирна | | |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ, АРХИВ,
АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.БАТЧИМЭГ